

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Авто зам засвар, арчлалт ТӨХК-ийн Налайх дүүрэг дэх салбарын 2025 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/009/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Нандинжаргал Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Санхүүгийн аудитын албаны аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 315558 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn Гэрээгээр гүйцэтгэсэн: Бэст фортуна аудит ХХК-ийн захирал: Ж.Оюунцэцэг Утас: 324338, 89116465, 98056465 Цахим хаяг: fortune2009audit@gmail.com
---	--



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-03-13 № 734

танай _____-ны № _____-т

АВТО ЗАМ ЗАСВАР АРЧЛАЛТЫН
НЭГТГЭЛ ТӨХК-ИЙН НАЛАЙХ
ДҮҮРЭГ ДЭХ САЛБАРЫН МЕНЕЖЕР
А.ЦАС-ЭРДЭНЭ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Авто зам засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн Налайх дүүрэг дэх салбарын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 431.1 сая төгрөгийн залруулаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар бүх явцыг санхүүгийн тайланд толилуулж, толилуулаагүй асуудал гараагүй болно.

Авто зам засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2025 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн 82 дугаар тушаалаар тус салбарын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд нийт орлогыг 2,632.0 сая төгрөг, нийт зардлыг 2,622.0 сая төгрөг, 10.0 сая төгрөгийн ашигтай ажиллахаар баталсан байна. Гүйцэтгэлээр 1,667.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,262.3 сая төгрөгийн зардал гарган, 595.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Нийт орлогын гүйцэтгэл 1,667.1 сая төгрөг болж төлөвлөснөөс 964.8 сая төгрөгөөр дутуу буюу 63.3

хувийн гүйцэтгэлтэй байгаа нь ээлжит засварын ажил, бусад орлогын төлөвлөгөөг биелүүлэх боломжгүй (2025 онд салбар болж зохион байгуулалтын өөрчлөлт хийгдсэнээс бие даан тендерт орох эрх хязгаарлагдсан)-ээс орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засгийн газрын 2023 оны 220 дугаар тогтоолын дагуу өөрчлөн зохион байгуулагдсан Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн дүрэмд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 108 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан, Авто зам засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн 2025 оны 25/06 дугаартай тогтоолоор Авто зам засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн Налайх дүүрэг дэх салбар болон зохион байгуулагдсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Авто зам засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2025 оны А/89 дугаартай тушаалаар баталсан компанийн тайлант оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг 88.5 хувиар биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
		2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,424,584.65	21,266,484.84
1.1.2	Дансны авлага	58,593,615.29	83,843,432.39
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	11,265,691.27	10,965,691.27
1.1.4	Бусад авлага	46,000.00	175,702,592.98
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	65,719,057.63	94,969,704.92
1.1.7	Урьдчилж төлсөн зардал, тооцоо	-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	138,048,948.84	386,747,906.40
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,083,614,588.24	858,296,813.44
1.2.2	Биет бус хөрөнгө	1,631,796,100.00	1,631,196,100.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,715,410,688.24	2,489,492,913.44
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,853,459,637.08	2,876,240,819.84
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1	Дансны өглөг	599,478,312.41	1,374,768,453.22
2.1.1.2	Цалингийн өглөг	-	45,124,074.00
2.1.1.3	Татварын өр	663,809,142.71	537,974,047.31
2.1.1.4	НДШ-ийн өглөг	111,137,816.77	51,041,850.62
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.12	Бусад өглөг	263,012.64	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,374,688,284.53	2,008,908,425.15
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,374,688,284.53	2,008,908,425.15
2.3	Эздийн өмч	839,162,304.18	839,162,305.18
2.3.1	Өмч: - төрийн	839,162,304.18	839,162,305.18
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,980,538,880.85	1,980,538,881.85
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	19,147,763.33	19,147,763.33
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	-941,635,125.18	-941,635,125.18
2.3.10	Тайлант үеийн ашиг (алдагдал)	-418,442,470.63	-418,442,470.63
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,478,771,352.55	1,478,771,354.55
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,853,459,637.08	3,487,679,779.70

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
		2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,183,985,585.52	1,666,875,966.10
2	Борлуулалтын өртөг	2,154,097,687.51	1,474,955,135.33
3	Нийт ашиг (алдагдал)	29,887,898.01	191,920,830.77
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	365,860.60	266,897.14
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	-	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	448,659,643.18	432,254,885.92
11	Санхүүгийн зардал	-	4,531,125.23
12	Бусад зардал	-	350,487,118.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг алдагдал	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-418,405,884.57	-595,085,401.24
19	Орлогын татварын зардал	36,586.06	26,689.72
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-418,442,470.63	-595,112,090.96
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал)	-418,442,470.63	-595,112,091.96
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	-418,442,470.63	-595,112,091.96

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023-12-31-ний үлдэгдэл	862,884,484.18	1,980,538,880.85	-	-941,635,125.18	1,901,788,239.85
2	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-		-	0.00	0.00
3	Залруулсан үлдэгдэл	862,884,484.18	1,980,538,880.85	-	-941,635,125.18	1,901,788,239.85
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-		-418,442,470.63	-418,442,470.63
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	0.00
6	Өмчид гарсан өөрчлөлт	(23,722,180.00)	-	19,147,763.33	-	-4,574,416.67
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	0.00
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	0.00
1	2024-12-31-ний үлдэгдэл	839,162,304.18	1,980,538,880.85	19,147,763.33	-1,360,077,595.81	1,478,771,352.55
2	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-		8,000,000.00	(24,326,886.81)	-16,326,886.81
3	Залруулсан үлдэгдэл	839,162,304.18	1,980,538,880.85	27,147,763.33	-1,384,404,482.62	1,462,444,465.74
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	0	0	-595,112,091.05	-595,112,091.05
5	Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0	0	0.00
6	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0	0	0	0.00
7	Зарласан ногдол ашиг	0	0	0	0	0.00
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0	0	0	0	0.00
9	2025-12-31-ний үлдэгдэл	839,162,304.18	1,980,538,880.85	27,147,763.33	-1,979,516,573.67	867,332,374.69

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

<i>/төгрөгөөр/</i>			
№	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,401,589,760.55	1,160,819,189.81
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,321,155,429.05	1,133,618,469.82
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,201,418.00	672,032.00
	Бусад мөнгөн орлого	79,232,913.50	26,528,687.99
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,367,896,181.08	1,111,691,580.22
	Ажиллагчдад төлсөн	584,125,604.00	643,704,526.51
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	169,326,840.45	262,852,397.53
	Бараа материал худалдан авахад төлсөн	591,604,561.00	133,776,160.00
	Ашиглалтын зардалд төлсөн	51,552,458.45	16,656,218.02
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	668,112,135.00	34,005,300.00
	Хүүний төлбөрт төлсөн	31,726.62	200,000.00
	Татварын байгууллагад төлсөн	80,529,679.22	5,543,931.72
	Даатгалын төлбөрт төлсөн	564,080.00	171,720.00
	Бусад мөнгөн зарлага	222,049,096.34	14,781,326.44
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	33,693,579.47	49,127,609.59
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	365,860.60	89,756,770.60
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Хүлээн авсан хүүний орлого	365,860.60	226,770.60
	Зээл, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	89,530,000.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	23,964,970.00	25,900,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	23,192,800.00	25,900,000.00
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	772,170.00	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(23,599,109.40)	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	89,530,000.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	89,530,000.00
	Бусад	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	17,546,837.00	94,142,500.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	17,546,837.00	94,142,500.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(17,546,837.00)	(4,612,500.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(7,452,366.93)	18,841,880.19
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,876,951.58	2,424,584.65
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,424,584.65	21,266,464.84

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/ төгрөгөөр/	
				Зөрүү	Зөрүү хувиар
1	Зам засвар арчлалтын ажил	1,523,580,000.00	1,417,062,963.24	-106,517,036.76	93.0
2	Машин механизмын орлого	591,384,900.00	0.00	-591,384,900.00	0.00
4	Бусад орлого	517,035,100.00	250,079,900.00	-266,955,200.00	48.4
5	Нийт орлого	2,632,000,000.0	1,667,142,863.24	-964,857,136.76	63.3
6	Үндсэн ба нэмэгдэл цалин	851,813,100.00	819,696,170.50	-32,116,929.50	96.2
7	Нийгмийн даатгалын шимтгэл	123,381,800.00	101,006,236.48	-22,375,563.52	81.9
8	Материалын зардал	737,785,510.00	268,883,700.00	-468,901,810.00	36.4
9	Тос тосолгоо	36,601,640.00	21,649,778.29	-14,951,861.71	59.1
10	Шатахуун	265,474,330.00	81,678,600.00	-183,795,730.00	30.8
11	Сэлбэг хэрэгсэл	51,904,000.00	32,191,060.00	-19,712,940.00	62.0
12	Дулаан уур ус	10,850,000.00	2,572,560.00	-8,277,440.00	23.7
13	Цахилгаан	4,800,000.00	2,288,650.00	-2,511,350.00	47.7
14	Тээвэр, бэлтгэл ажиллагаа	22,200,000.00	23,650,000.00	1,450,000.00	106.5
15	Хөдөлмөр хамгааллын зардал	30,809,640.00	24,643,000.00	-6,166,640.00	80.0
16	Томилт /хээрийн нэмэгдэл	20,219,300.00	1,136,900.00	-19,082,400.00	5.6
17	Холбоо бичиг хэрэг	7,379,200.00	2,557,400.00	-4,821,800.00	34.7
18	Хангамжийн материалын зардал	2,400,000.00	15,434,390.00	13,034,390.00	643.1
19	Машин механизмын түрээс	27,000,000.00	130,635,929.09	103,635,929.09	483.8
20	Үндсэн хөрөнгийн элэгдэл	74,145,080.00	243,484,158.20	169,339,078.20	328.4
21	Бусад зардал	22,074,320.00	6,864,980.00	-15,209,340.00	31.1
22	Газрын төлбөр	24,590,540.00	22,319,120.00	-2,271,420.00	90.8
23	Ажилчдын эрүүл мэнд, чийрэгжүүлэлт, дасгал хөдөлгөөн зориулах	4,200,000.00	3,600,000.00	-600,000.00	85.7
24	Сургалтын зардал	4,700,000.00	0.00	-4,700,000.00	0.00
25	Тэтгэвэр тэтгэмжийн зардал	31,660,000.00	27,154,000.00	-4,506,000.00	85.8
26	Материалыг зардал	0.00	0.00	0.00	0.00
27	Цэвэр бохир ус	4,650,000.00	1,384,250.00	-3,265,750.00	29.8
28	Ахмадын зардал	3,000,000.00	4,000,000.00	1,000,000.00	133.3
29	Бусад татвар, төлбөр хураамж	148,592,710.00	350,487,100.00	201,894,390.00	235.9
30	Тээврийн хэрэгсэлийн татвар оношлогоо	1,799,130.00	10,455,300.00	8,656,170.00	581.1
31	Ажилчдын нийгмийн асуудал шийдвэрлэх	48,716,200.00	26,221,700.00	-22,494,500.00	53.8
32	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	60,800,000.00	33,513,450.00	-27,286,550.00	55.1
	Банкны үйлчилгээний зардал	480,000.00	188,600.00	-291,400.00	39.3
33	Нийт зардал	2,622,026,500.00	2,257,697,032.56	-364,329,467.44	86.1
61	Татварын өмнөх ашиг (+), алдагдал (-)	9,973,500.00	-590,554,200.00	-600,527,669.32	0.00
62	Орлогын татварын зардал	997,300.00	26,700.00	-970,600.00	2.7
63	Цэвэр ашиг (+), алдагдал (-)	8,976,200.00	-590,580,869.32	-559,557,069.32	6,579.4)
28	Ахмадын зардал	3,000,000.00	4,000,000.00	1,000,000.00	133.3
29	Бусад татвар, төлбөр хураамж	148,592,710.00	350,487,100.00	201,894,390.00	235.9

**“Автозам засвар, арчлалтын нэгтгэл” ТӨХК-ийн Налайх дүүрэг дэх салбарын
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

30	Тээврийн хэрэгсэлийн татвар оношлогоо	1,799,130.00	10,455,300.00	8,656,170.00	581.1
31	Ажилчдын нийгмийн асуудал шийдвэрлэх	48,716,200.00	26,221,700.00	-22,494,500.00	53.8
32	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	60,800,000.00	33,513,450.00	-27,286,550.00	55.1
	Банкны үйлчилгээний зардал	480,000.00	188,600.00	-291,400.00	39.3
33	Нийт зардал	2,622,026,500.00	2,257,697,032.56	-364,329,467.44	86.1
61	Татварын өмнөх ашиг (+), алдагдал (-)	9,973,500.00	-590,554,200.00	-600,527,669.32	0.00
62	Орлогын татварын зардал	997,300.00	26,700.00	-970,600.00	2.7
63	Цэвэр ашиг (+), алдагдал (-)	8,976,200.00	-590,580,869.32	-559,557,069.32	6,579.4)

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 431,082.4 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч, 389,187.1 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 41,895.3 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгөв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
2025 оны 04 дүгээр сарын 01-нээс гэрээний дагуу 1 жилийн хугацааны орлогыг урьдчилан төлсөн үед сүүлийн 3 сарын төлбөрийг урьдчилж орсон орлогоор бүртгээгүй -	1	13,000.0			1	13,000.0	1	13,000.0				
Дүн	1	13,000.0			1	13,000.0	1	13,000.0				

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**“Автозам засвар, арчлалтын нэгтгэл” ТӨХК-ийн Налайх дүүрэг дэх салбарын
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Нэг аж ахуйн нэгжтэй 2023 оны 02 дугаар сарын 22-ны өдөр хийсэн 23/04 дугаартай гэрээгээр сарын түрээсийн төлбөр 1.5 сая, нийт 46.5 сая төгрөг төлөхөөс төлөгдөөгүй 38.7 сая төгрөгийн төлбөрийг борлуулалтын орлого, авлагаар аккруэл сууриар бүртгээгүй	1	38,700.0			1	38,700.0							
Гэрээний дагуу 2025 оны 04 дүгээр сарын 1-нээс эхлэн сарын 4.5 сая төгрөгөөр 1 жилийн хугацааны орлогыг урьдчилан төлсөн 3 дугаар улирлын байдлаар бүгдийг орлогоор бүртгэж сүүлийн улирлын орлогыг урьдчилж орсон орлогоор бүртгээгүй, тайлангийн жилийн эцэст төлөгдөөгүй 0.5 сая төгрөгийг орлого, авлагаар бүртгээгүй	1	500.0					1	500.0					
2021-2025 оны 4 дүгээр сар дуусталх хугацааны санхүүгийн үйл ажиллагаанд татварын шалгалт хийгдэж ХХОАТ 8,421.9 мянга, газрын төлбөрт 7,931.4 мянга, НӨАТ-т 334,133.8 мянга, нийт 350,487.1 мянган төгрөгийн хугацааны алданги, торгуулийн акт тогтоогдож байгуулагад хохирол учирсан	1	350,487.1			1	350,487.1							
Авто зам засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-аар дамжуулаагүй, санхүүжилтаас бусад салбарын өөрийн борлуулалт, худалдан авалтад НӨАТ тооцоогүй нь татварын торгууль, алданги тавигдах эрсдэл үүсгэсэн	1	27,090.7					1	27,090.7					
Томилолтын тооцоо, тээврийн хөлсний тооцоог тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлын дансанд бүртгэсэн	1	14,304.5					1	14,304.5					
Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд ирүүлээгүй, өмнөх зөвлөмжийн зөрчлийг давтан гаргасан	1	0			1	0							
Дүн	6	431,082.4			3	389,187.1		3	41,895.2				